



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 06 сарын 18 өдөр

Дугаар A/316

Улаанбаатар хот

**“Шарилжгүй Улаанбаатар-5” аян
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны А/195 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд, сууц өмчлөгчдийн холбоо, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд эзэмшил талбайн болон орчны 50м хүртэлх газрын шарилж, хог ургамлыг цэвэрлэж тайрах, хадах ажлыг зохион байгуулсугай.

2. Хөл газрын хог ургамал, шарилжтай тэмцэх ажлын нэгдүгээр үе шатыг 2020 оны 06 дугаар сарын 20-ноос 07 дугаар сарын 05-ны хооронд, хоёрдугаар үе шатыг 08 дугаар сарын 05-наас 08 дугаар сарын 20-ны өдрийн хооронд хорооны хэмжээнд зохион байгуулж ажиллахыг хорооны Засаг дарга нарт даалгасугай.

3. Хуваарьт зам талбайн болон үерийн далан, суваг шуудуу дагуу ургасан шарилж, хог ургамлыг цэвэрлэж, хог хаягдлыг ачиж тээвэрлэхийг Баянгол Шинэ-Өргөө ОНӨААТҮГ /Б.Мөнгөнсүх/-т үүрэг болгосугай.

4. Тус ажилд шаардагдах хөрөнгийг холбогдох зардлаас санхүүжүүлэхийг Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч /Э.Батбилэг/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА